



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар A/21

Дархан

Г
Төвийн албан хаагчдад улирлын ажлын
үр дүнг үнэлж мөнгөн урамшуулал
олгох журам

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2023 оны 442 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнг үнэлж мөнгөн урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмын дагуу улирал бүр мөнгөн урамшуулал олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Ш.Батчимэг)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү журам гарсантай холбогдуулан төвийн даргын 2023 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан ажилтны улирлын ажлын үр дүнг үнэлж мөнгөн урамшуулал олгох журмыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

С.АЛТАНДОЛГИОН



Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын
оны дүгээр сарын-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

ТБАГУҮГ
4518263378
ХУВЬСАН № 9023291

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
АЛБАН ХААГЧИД УЛИРЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЖ
МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх хэсэг, Засгийн газраас төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг үндэслэн төвийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Төсвийн шууд захирагч нь төрийн албан хаагчид гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан ажилтанд улирал бүр мөнгөн урамшуулал олгоно.

1.3. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвтөө тусгана.

**Хоёр. Улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн
шалгуур үзүүлэлт, үнэлгээ**

2.1. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг ажилтны гүйцэтгэлийн тайлан маш сайн, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн ажилтанд олгоно.

2.2. Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгоход дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

2.2.1. Төрийн үйлчилгээний мэргэшлийн (TYM) зэрэглэлд хамаардаг ажилтныг үнэлэх шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт /TYM зэрэглэлд хамаардаг албан хаагч/	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ /хувь/
1	Улирлын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ	80
2	Зөвлөл, хороонд ажилласан үнэлгээ	10
3	Шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилтийн үнэлгээ	5
4	Олон нийтийн ажлын манайлал, идэвх, оролцоо	5
	Нийт оноо	100

2.2.2. Төрийн үйлчилгээний (TY) зэрэглэлд хамаардаг ажилтныг үнэлэх шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт /TY зэрэглэлд хамаардаг албан хаагч/	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ /хувь/
1	Улирлын гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээ	80
2	Санаачилсан ажлын үр дүн	10
3	Үүрэг даалгаврын гүйцэтгэлийн үнэлгээ	5
4	Олон нийтийн ажлын манайлал, идэвх оролцоо	5
	Нийт оноо	100

Гурав. Улирлын мөнгөн урамшуулал олгох хувь, хэмжээ



3.1. Үнэлгээний багаас хийсэн улирлын гүйцэтгэлийн тайлангийн дүгнэлтийг үндэслэж энэ журмын 2.2.1, 2.2.2-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтанд олгоно.

3.2. Улирлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь ажилтны албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байх ба ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараах хувь хэмжээгээр тооцож төсвийн шууд захирагчийн шийдвэрээр олгоно.

№	Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ %/	Мөнгөн урамшуулал олгох хэмжээ %/
1	85.0- 90.0	30
2	90.1 – 92.5	35
3	92.5 - 95.0	40
4	95.1 - 97.5	45
5	97.6 - 100	50

3.3. Улирлын ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн дүн 85.0 хувиас бага ажилтанд мөнгөн урамшуулал олгохгүй.

3.4. Сахилгын шийтгэл хүлээсэн ажилтны сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.

3.5. Улирлын мөнгөн урамшууллыг дараа улирлын эхний сард багтааж олгоно.

-----оОо-----оОо-----